



ЭНЭТХЭГ - МОНГОЛЫН ХАРИЛЦАА

Ёгишвар Варма

*Энэтхэг улсаас Монгол улсад
суугаа Элчин сайд*

Энэтхэг, Монгол хоёр орон Азийн эртний соёл иргэншилт улс орнууд билээ. Газар зүйн хувьд хэдийгээр алслагдсан ч энэхүү хоёр орон нь 2700 гаруй жилийг хамарсан соёл иргэншлийн холбоотой. Энэ нь хэл, утга зохиол, шашин, анагаах ухаан, аман зохиолоос соёл, зан заншил хүртэлх хүний үйл ажиллагааны бүхий л хүрээг хамарсан нь сэтгэл хөдөлгөм, нягт, бас хоорондоо салшгүй холбоотой юм. Монгол Ганжуур, Данжуур нь энэхүү баялаг соёл иргэншлийн солилцооны бодит баримт билээ. Бидний өвөг дээдсийн харилцаа холбооны энэхүү баялаг өв нь тус хоёр орны хооронд өнөө үед тогтсон нөхөрсөг харилцааны үндэс суурь болдог.

Энэтхэг улсын тусгаар тогтнолын үед Жавахарлал Неругийн санаачилгаар 1947 оны гуравдугаар сард зохион байгуулагдсан Азийн харилцааны анхдугаар бага хуралд Монголын төлөөлөгчид оролцохоор Шинэ Делийг зорьжээ. Тэр үеэс хойш хоёр орны удирдагчид бие биетэйгээ байнгын харилцаатай байж ирсэн. Энэ нь 1955 оны арван хоёрдугаар сарын 24-нд хоёр орны хооронд дипломат харилцаа тогтооход нөлөөлсөн. Энэтхэг нь тэр үеийн социалист нөхөрлөлийн бус орнуудаас Монголтой иж бүрэн дипломат харилцаа тогтоосон хамгийн анхдагч улс юм. Ийм нягт холбоотой байсан учраас Монгол Улсыг НҮБ-д гишүүнээр элсэхэд Энэтхэг улс идэвхтэй дэмжиж байв. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн X чуулган дээр Энэтхэгийн байнгын төлөөлөгч ноён Кришна Менон хэлэхдээ “Монгол бол өчигдөр юмуу, өнөөдөр үүсч байгуулагдаагүй юм. Харин олон зууны турш тусгаар улс байсаар ирсэн. Ийм учраас БНМАУ нь бусад улсын нэгэн адил НҮБ-ын гишүүн байх бүрэн эрхтэй” гэж хэлсэн. Пандит Неру НҮБ-ын Ерөнхий Ассамблейн XV чуулган дээр НҮБ-д Монголыг элсүүлэх талаар бусдыг итгүүлэхүйц, маш хурц үг хэлж, “НҮБ-д ийм олон орныг хүлээн авсан атал яахаараа Монголыг гадна нь үлдээх ёстой гэж? Тэрээр ямар буруу үйлдэл хийсэн юм бэ? Дүрэмтэй харшлах ямар алдаа гаргасан юм бэ? Монголын ард түмний амгалан тайван, энхийг эрхэмлэсэн алхмууд нь хөгжил дэвшлийн төлөө идэвхтэй тэмцэж байгаа улс орон гэдгийг харуулж буйн нотолгоо бөгөөд зарчмын үүднээс үзэхэд, энэхүү нэр хүндтэй байгууллагад түүнийг оруулахгүй байх нь туйлын буруу санагдана” гэжээ.

Дипломат харилцаа тогтоосны дараахан Энэтхэгийн нэрт философич, улс төрч тухайн үеийн Энэтхэгийн дэд ерөнхийлөгч, доктор С.Радхакришнан 1957 онд Монголд түүхэн айлчлал хийсэн ба энэхүү айлчлал нь хоёр орны хооронд байнгын

өндөр түвшний айлчлалын эхлэл болсон юм. Түүнээс хойш Энэтхэгийн гурван дэд ерөнхийлөгч доктор Шанкар Даял Шарма (1992 оны дөрөвдүгээр сар), К.Р.Нараянан (1996 оны есдүгээр сар), Кришан Кант (1999 оны наймдугаар сар) нар Монголд айлчилжээ. Энэтхэгийн ерөнхийлөгч Р.Венкатарамана 1988 оны долдугаар сард Монгол улсад Төрийн айлчлал хийсэн. Монголын талаас, Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал (1973), Ардын Их хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж.Батмөнх (1989 оны гуравдугаар сар), Ерөнхийлөгч П.Очирбат (1994 оны хоёрдугаар сар), Ерөнхийлөгч Н.Багабанди (2001 оны нэгдүгээр сар), Ерөнхий сайд Н.Энхбаяр (2004 оны нэгдүгээр сар) нар Энэтхэг улсад тус тус айлчилжээ.

Энэхүү байнгын дээд түвшний харилцан айлчлал нь манай хоёр орны хамтын ажиллагааг орчин үед хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Манай хоёр талын харилцаа нь ойрын жилүүдэд мэдэгдэхүйц өргөжин тэллээ. 2001 оны нэгдүгээр сард Ерөнхийлөгч Н.Багабандийн хийсэн Төрийн айлчлал, 2004 оны нэгдүгээр сард Ерөнхий сайд Н.Энхбаярын хийсэн айлчлал нь бидний хамтын ажиллагаанд шинэ эрч хүч авчирлаа. Эрхэмсэг ноён Н.Энхбаярын айлчлалаас хойш хоёр талын харилцаа нь хамтын ажиллагааны бүхий л салбарыг хамарсан түншлэлийн түвшинд хүрлээ. Түүнээс хойш бидний хамтын ажиллагааг баяжуулсан хэд хэдэн шинэ санал, санаачлагууд хэрэгжиж байна.

Хоёр парламентын хоорондох харилцан айлчлал ч их идэвхжлээ. Энэтхэгийн талаас Лок Сабхагийн дарга нар доктор Г.С.Дхиллон (1974 оны долдугаар сар), доктор Балрам Жхакхар (1985 оны аравдугаар сар), Шив Раж Патил (1995 оны долдугаар сар), П.А.Сангма (1997 оны аравдугаар сар), Г.М.С.Балаёги (2001 оны долдугаар сар), Ражя Савхагийн дэд дарга Нажма Хептүллах нар Парламентын төлөөлөгчдийг Монголд тэргүүлэн айлчилж байжээ. Монголын талаас, Ю.Цэдэнбал (1959, 1973), Ж.Батмөнх (1989), Н.Багабанди (1995), Р.Гончигдорж (1998), С.Төмөр-Очир (2003) нар Монголын төлөөлөгчдийг тэргүүлэн Энэтхэгт айлчилсан юм. Хоёр Парламент нь нягт хамтын ажиллагаатай бөгөөд энэ талаар протоколд гарын үсэг зурсан байна.

Сүүлийн жилүүдэд хоёр орны хооронд бүх салбарын хамтын ажиллагааны нарийвчилсан эрхийн актуудаар баталгаажсан 35 гэрээ хэлэлцээрт хоёр тал гарын үсэг зуржээ. Эдгээрийн заримаас нь дурдвал, Нөхөрсөг харилцаа, хамтын ажиллагааны хэлэлцээр, Худалдаа ба эдийн засгийн салбарт хамтран ажиллах гэрээ, Татварыг давхардуулан хураахаас сэргийлэх гэрээ, Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах гэрээ, Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах гэрээ, Гэмт хэрэгтнийг харилцан шилжүүлэх гэрээ, Дипломат ба албан паспорт эзэмшигч нар харилцан визгүй зорчих хэлэлцээр, Дархан-Уул аймагт Энэтхэг Монголын хамтарсан судалгаа шинжилгээний "Найрамдал" хөдөө аж ахуйн парк байгуулах талаар хамтран ажиллах санамж бичиг, МУҮИС-д Санскрит, Буддийн судлалын танхим байгуулах талаар хамтран ажиллах санамж бичиг, Улсын Төв номын санд Буддын гар бичмэлүүдийг дижитал хэлбэрт шилжүүлэх хэлэлцээр зэрэг болно.

Эдгээр дээд түвшний харилцан айлчлал нь яамдын түвшний айлчлал ба байнгын албан ёсны айлчлалтай хамт хийгдэж иржээ. Хоёр талын гарын үсэг зурсан гэрээ хэлэлцээрийн бүрэн жагсаалтыг хавсаргалаа. Ийнхүү хоёр талын харилцан айлчлалаас гадна манай хоёр орны удирдагчид нь олон улсын томоохон хурал, зөвлөгөөн болон

бүс нутгийн бага хурал, уулзалтын үеэр байнга харилцан уулзалдаж ирлээ. Олон улсын ба бүс нутгийн уулзалтын үед хоёр орон нь өөрсдийн байр сууриа харилцан зохицуулах эртний уламжлалтай юм. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн өргөтгөсөн гишүүнд Энэтхэг улсыг байнгын гишүүнээр элсэхэд нь Монгол улсын үзүүлж байгаа дэмжлэгийг Энэтхэг улс гүнээ хүндэтгэн үздэг.

Манай хоёр орны хоорондох ах дүүгийн нөхөрсөг харилцааны билэг тэмдэг болгож Энэтхэгийн Шинэ Дели хотод нэгэн гудамжийг “Улаанбаатарын гудамж”, Улаанбаатар хотод нэгэн гудамжийг “Махатма Ганди (Энэтхэг үндэстний эцэг)-ийн гудамж” хэмээн тус тус нэрлэсэн. Махатма Гандийн цээж баримлыг энэ гудамжинд босгосон. 2006 оны есдүгээр сард Энэтхэг, Монголын хамтарсан шуудангийн дурсгалын маркуудыг гаргасан.

Сүүлийн жилүүдэд, Энэтхэг улс нь өөрийн талаас Монголд үзүүлж байгаа хөгжлийн даруухан тусламжаа өргөтгөсөөр ирлээ. Энэтхэг улсаас үзүүлж байгаа хөгжлийн тусламжийг дор товч жагсаая:

(1) Оюутны тэтгэлэг: Энэтхэг улсын Их дээд сургуулиудад Монгол оюутнуудын дээд боловсрол олж авахад нь зориулсан тэтгэлгийг Энэтхэг улс сүүлийн жилүүдэд өргөтгөсөөр ирлээ. Өнөөгийн байдлаар бид жил бүр 40 (эдгээрийн 30 нь байнгын, 10 нь байнгын бус тэтгэлэг юм) оюутны тэтгэлгийг Монгол оюутанд олгож байна. Өнөөдөр Энэтхэг улсад боловсрол эзэмшсэн нилээд олон монголчууд Монгол улсын төрийн байгууллагууд болон хувийн хэвшлийн секторт өндөр алба хашиж байгааг энд дурдахдаа би их баяртай байна.

(2) Богино хугацааны сургалтууд: Дээр дурдсан оюутны тэтгэлгээс гадна, Энэтхэгийн Техник, Эдийн засгийн Хамтын ажиллагааны хөтөлбөр (ИТЕС)-ийн хүрээнд жил бүр 50 хүнийг хөдөө аж ахуй, жижиг үйлдвэрлэл, мэдээллийн технологи, банк, менежмент, хөдөөгийн хөгжил зэрэг төрөл бүрийн салбарын ажилтнуудыг дадлагажуулах боломж олгож байна. Эдгээр дадлага эзэмшүүлэх хөтөлбөрүүд нь Монгол дахь хүний нөөцийн хөгжилд тодорхой хувь нэмэр болдог.

(3) Боловсрол: Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээгээр Энэтхэг улсын Засгийн газар Энэтхэг-Монголын хамтарсан дээд сургуулийг Улаанбаатар хотноо 2003 оны 9-р сард нээсэн. Одоо энэ сургуульд 5 энэтхэг багш ажиллаж байгаа бөгөөд тэд англи хэл, мэдээллийн технологи, математикийн хичээлийг тус тус зааж байна. Түүнчлэн Энэтхэг улс нь Монгол улсын сургуулийн хичээлийн хөтөлбөрүүдийг сайжруулах, тэдгээрт е-боловсролыг нэвтрүүлэхэд туслалцаа үзүүлж ирлээ.

(4) Мэргэжлийн сургалт: 1996 онд, ИТЕС-ийн хүрээнд Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэр, Урлалын Сургуулийг тусгай мэргэжлийн 8 чиглэлийн тоног төхөөрөмжтэйгээр Улаанбаатар хотод хичээллүүлж эхэлсэн. Эдгээрт автомеханикч, сантехникч, цахилгаанчин, радио, телевизийн засварчин, компьютерийн программч, үнэт чулуу зүсэгч, өнгөлөгч, үнэт чулуун дээр бичигч зэрэг багтана. Энэ төвд жил бүр нийт 450 оюутан дээрх чиглэлийн тоног төхөөрөмж дээр тусгай мэргэжил эзэмшиж байна. Энэ төвд дахин зарим шинэ тоног төхөөрөмж нэмж нийлүүлэх төсөл одоо яригдаж байна.

(5) Эдийн засгийн тусламж: Энэтхэг улсын хөнгөлөлттэй зээлээр бага оврын цементийн үйлдвэрийг Ховд аймагт байгуулсан. Ерөнхий сайд Н.Энхбаярын Энэтхэг

улсад хийсэн айлчлалын үеэр Энэтхэг улсын бараа, үйлчилгээ болон өөр бусад төслийг Монголд оруулахад зориулж 10 сая ам. долларын хөнгөлөлттэй зээл олгохоор болсон. Одоогоор дээрх зээлийн хэмжээг 20 сая ам. долларт хүргэж нэмэгдүүлэх тухай ярьж байна.

(6) Мэдээллийн технологийн салбар: Энэтхэг улсын засгийн газар 2002 оны 10-р сард Мэдээллийн технологийн салбарт 1 сая ам. долларын санхүүжилтээр “Мэдээлэл, Харилцаа холбооны технологийн Атал Бихари Важпайн төв”-ийг нээсэн. Энэ төв нь компьютерийн нарийн технологитой лабораториор тоноглогдсон ба видео-хурал хийх төхөөрөмж бүхий Монголд байгаа цорын ганц төв юм. 2002 онд Энэтхэг улсын Засгийн газар Говь-Алтай, Өмнөговь, Архангай, Хэнтий, Сэлэнгэ аймгийн төвд энэ төвийн салбар болох Иргэний мэдээллийн таван төв (CICs)-ийг байгуулсан. 2004 оны 1-р сард Ерөнхий сайд Н.Энхбаярын айлчлалын үеэр дээрх төвийг өргөтгөхөөр тохирсон ба энэ хүрээнд Хөвсгөл; (б) Булган; (в) Хархорин; (г) Дорнод; (д) Сүхбаатар аймгийн төвд Иргэний мэдээллийн 5 төвийг шинээр нэмж байгуулжээ. Одоогоор нийт 16 аймгийн төв Улаанбаатар хот дахь видео хурлын тоног төхөөрөмжтэй холбогдоод байна. Монгол улсын Засгийн газар дээрх тоног төхөөрөмжийг ашиглах замаар зайн сургалтыг аль хэдийнээ зохион байгуулдаг болжээ.

(7) Дижиталчлах процесс: Монгол улс нь үлэмж арвин үнэт гар бичмэлийн өлгий нутаг бөгөөд эдгээр нь нийт хүн төрөлхтний соёл, утга зохиолын гайхамшигт өв юм. Хоёр Засгийн газар эдгээр үнэт гар бичмэлийг дижитал хэлбэрт хөрвүүлэх шийдэлд хүрсэн ба ингэснээр тэдгээрийн хамгаалалтыг баталгаажуулах, дэлхий нийтийн хүртээл болгох боломж бий болж байгаа юм. Энэтхэгийн Соёлын харилцааны зөвлөл (ICCR) ба Улаанбаатар дахь Улсын Төв Номын сангийн хооронд 2006 оны 6-р сарын 9-нд Буддын гар бичмэлүүдийг дижиталчлах хэлэлцээрт гарын үсэг зурсан. Монгол Ганжуур, Данжуурыг дижиталчлах ажил 2006 оны 9-р сард эхэлж одоогоор энэ нь төгсгөлийн шатандаа орж байна.

(8) Монгол улсын Үндэсний Их сургууль дээр Санскрит, Буддын судалгааны тэнхим байгуулах ажиллагаа: Энэтхэгийн Засгийн газар, Монгол улсын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны Яамны хооронд байгуулсан гэрээгээр 2006 оны 4-р сард Монгол улсын Үндэсний Их сургууль дээр Санскрит, Буддын судалгааны тэнхим байгуулагдсан. Түүнээс хойш Санскрит, Буддын философи тус Их сургууль дээр амжилттай хэрэгжиж байна. 2006 онд Монгол улсын Үндэсний Их сургуульд Санскрит хэлний профессор нэг семестр ажилласан ба 2007 оны 9-р сард өөр нэг профессор багшлахаар ирнэ.

(9) Теле-боловсрол ба теле-эмнэлгийн төсөл: Монгол улсын Гадаад харилцааны сайд асан Ц.Мөнх-Оргилын 2005 оны 12-р сард Энэтхэг улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр Энэтхэгийн Засгийн газар Монголд зориулж теле-боловсрол ба теле-эмнэлгийн төслийг хэрэгжүүлэхээ мэдэгдэв. Энэ төслийн хүрээнд Монголын боловсролын байгууллагууд Энэтхэгийн боловсролын байгууллагуудтай хиймэл дагуулын тусламжтай холбогдох юм. Үүнтэй нэг адил, Монголын нэгээс хоёр эмнэлгийг Энэтхэгийн эмнэлгийн байгууллагуудтай холбоно. Энэхүү төхөөрөмжийн тусламжтай орчин үеийн технологи ашиглан Монгол улс нь чанартай боловсрол, чанартай эмнэлгийн үйлчилгээг авах боломжтой болно.

(10) Хөдөө аж ахуйн салбар: Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах гэрээний хүрээнд 1998 онд Дархан-Уул аймгийн ойролцоо Энэтхэг Монголын “Найрамдал” фермийг байгуулсан. Тэр цагаас хойш хур тунадас багатай, зун богино, өвөл урт хүйтэн болдог Монгол орны цаг уурын өвөрмөц онцлогт нийцсэн улаан буудай, төмсний үрийн чиглэлээр Дарханы Газар тариалангийн судалгааны лабораторит зарим судалгааны ажил хийгджээ. Одоо “Найрамдал” фермийг газар тариалангийн жишиг ферм болгох зорилт тавьж байна. Энэ зорилгоор 2004 оны 7-р сард Энэтхэгийн хоёр мэргэжилтэн тус фермд ажиллажээ. Мөн Энэтхэг улсын мэргэжилтнүүд Монголд ирж хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн хамгийн тохиромжтой бодлогын баримт бичиг боловсруулахад Монголын эрх баригчдад тусалж байлаа. Хоёр орон сарлагийн судалгааны чиглэлд хамтран ажиллаж байна. 2005 оны 12-р сард Монгол улсын Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргилын Энэтхэг улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр Энэтхэг Монголын хамтарсан судалгааны “Найрамдал” хөдөө аж ахуйн парк байгуулах талаар хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. Энэхүү хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд тус паркт Энэтхэгийн засгийн газар хөдөө аж ахуйн тоног хэрэгсэл, трактор, ачааны машин, бороожуулагч нийлүүлнэ.

(11) Нарны эрчим хүч: 2004 оны 1-р сард Ерөнхий сайд Н.Энхбаярын айлчлалын үеэр Энэтхэг улсын Засгийн газар Монгол улсын хөдөөгийн нэгэн сууринг нарны эрчим хүч ашиглан цахилгаанжуулахаар шийдвэрлэсэн. Үүнтэй уялдуулан Энэтхэг улсын Засгийн газар Хэнтий аймгийн Дадал суманд нарны эрчим хүчний туршилтын төсөл амжилттай хэрэгжүүлсэн. Үүнийг 2006 оны 4-р сард албан ёсоор хүлээлгэн өгчээ.

(12) Худалдаа, эдийн засгийн салбар: Ерөнхий сайд Энхбаярын айлчлалын үеэр хоёр орны хооронд тогтсон улс төр, үзэл санааны нягт хэлхээ холбоотой ч түүнийг харилцан бие биедээ ашигтай худалдаа, эдийн засгийн солилцоонд шилжүүлэх бололцоо хомс байна гэж Ерөнхий сайдууд үзсэн. Тийм учраас Энэтхэгийн худалдааны үзэсгэлэнг Монголд зохион байгуулах шийдвэр гарсан. Энэ үзэсгэлэнг 2004 оны 9-р сард Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан байна. Мэдээллийн технологи, биотехнологи, эм үйлдвэрлэлийн чиглэлийн хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих зорилгоор дээрх чиглэлүүдийн бага хурлуудыг үзэсгэлэнгийн үеэр давхар зохион байгуулжээ. Энэхүү арга хэмжээ нь хоёр орны бизнесийн хүрээнийхний анхаарлыг ихээхэн татсан юм. Хоёр талын худалдаа нь нэлээд хэдэн жилийн турш 1 сая ам. долларын хүрээнээс хэтрэхгүй байсан ба харин дээрх арга хэмжээнээс хойш үлэмж өссөн байна. Энэтхэг улс нь бас Монгол оюутнуудад боловсрол олгох хамгийн шилдэг газруудын нэгээр тодрон гарч ирлээ.

(13) Батлан хамгаалах салбар: 2003 оны 10-р сараас Батлан хамгаалахын хамтын ажиллагааны чиглэлд ихээхэн дэвшил гарлаа. Монгол улсын Батлан хамгаалахын сайд 2003 оны 8-р дугаар сар, 2005 оны 5-р сард тус тус Энэтхэг улсад айлчлав. Энэтхэгийн Батлан хамгаалахын Төрийн сайд Шри М.М.Паллам Ражу 2006 оны тавдугаар сард Монгол улсад айлчилсан. Энэтхэг улс нь Монголын батлан хамгаалахын салбар дахь хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зорилгоор англи хэл эзэмших, энх тайвнаар орших, цэргийн операци хэрэгжүүлэх, сургуулилтын хэрэгсэл нийлүүлэхээр тохирсон юм. Одоогоор Монголын батлан хамгаалахын хүний нөөцийг бэхжүүлэхэд зориулж

жил бүр 10 албан хаагчийг Энэтхэгт явуулж сургах боломж нээгдээд байна. Мөн хоёр орны хамтарсан цэргийн сургуулилтын анхныхыг нь 2004 оны 10-р сард Улаанбаатарт, хоёрдахийг нь 2005 оны 12-р сард Энэтхэгт зохион байгуулжээ. 2006 оны 8-р сард Улаанбаатар хотноо зохиосон олон улсын “Хааны эрэл” цэргийн сургуулилтанд Энэтхэг улс оролцсон. Энэтхэгийн Засгийн газар Монгол улсын Зэвсэгт хүчинд шүхэр бэлэглэсэн. Батлан хамгаалахын өөр бусад чиглэлд хамтран ажиллах талаар одоо харилцан хэлэлцэж байна. Батлан хамгаалахын салбарт хамтран ажиллах чиглэлээр Хамтарсан ажлын хэсэг ажиллаж байгаа бөгөөд Энэтхэг-Монголын Хамтарсан ажлын хэсгийн анхдагч уулзалт 2006 оны 3-р сард Улаанбаатарт зохиогдсон байна.

Хоёр талын болон олон улсын асуудлаар үзэл бодлоо харилцан солилцох бололцоо нээсэн хоёр улсын Үндэсний Аюулгүй байдлын байгууллагуудын хоорондох уулзалт-ярилцлага тогтмол зохиогдох боллоо.

(14) Оюун санаа ба соёлын салбар: Манай хоёр орны хооронд тогтсон оюун санааны болон соёлын өнө эртний хэлхээ холбоог харгалзан Энэтхэг улсын Засгийн газар Бодь Гаяад Монгол хийд байгуулахад зориулж газар олгосон. Ерөнхий сайд Н.Энхбаярын Энэтхэг улсад хийсэн айлчлалын үеэр энэхүү хийдийн шав тавих ёслол хийгдсэн байна. Буддизмын энэхүү ариун дагшин газарт Монгол хийд барих ажил тун удахгүй эхэлнэ. Энэтхэг улсын Засгийн газар Дели дэх Жавахарлал Неругийн Их сургуульд Монгол судлалын тэнхим үүсгэн байгуулсан ба энэхүү тэнхим нь 2005 он хүртэл үйл ажиллагаа явуулж байгаад, одоогоор үйл ажиллагаа нь зогсжээ.

(15) Онцгой байдлын тусламж: Сайн түншийн хувьд, Энэтхэг улс нь Монгол улсад хоол хүнс, эмнэлгийн хэрэгслийн онцгой шаардлагатай тусламжийг зуд, ган гачиг тохиолдсон үед үзүүлж ирлээ.

Дээр дурьдсанаас дүгнэж үзэхэд, манай хоёр орон нь сүүлийн 50 жилд нягт хамтын ажиллагаатай явж иржээ. Энэхүү түүхт хамтын ажиллагаа нь ойрын ирээдүйд улам тогтвортой болох шинжтэй бөгөөд энэ нь хоёр орны өнө эртний соёл иргэншлийг бүр ч ойртуулах болно.

INDIA-MONGOLIA RELATIONS

Yogeshwar Varma
Ambassador of India to Mongolia

India and Mongolia are two ancient civilisations of Asia. Though geographically far apart, the two countries have had civilisational links spanning over a period of 2700 years. These links are fascinating, intense and inseparable; transcending all human activities from language, literature, religion, medicine, and folklore to culture and traditions. Mongolian Tanjur and Kanjur are testimony to these rich civilisational exchanges. Given such a rich legacy of interaction, assimilation and exchanges by our ancestors, it is but natural that the two countries have established very close and friendly relations in modern times.

Around the time of India's independence, a Mongolian delegation went to New Delhi to attend the 1st Asian Relations Conference held in March 1947 at the initiative of Pt. Jawaharlal Nehru. Since then the leadership of the two countries have been in constant contact with each other. This led to establishment of diplomatic relations between our two countries on December 24, 1955. India was the first country outside the then Socialist block to establish full diplomatic ties with Mongolia.

Given our close ties, India strongly advocated Mongolia's case for UN membership. At the 10th UN General Assembly, the Indian Permanent Representative Mr. Krishna Menon said, "Mongolia was founded neither yesterday nor today, but has been existing as an independent State over many centuries. Hence, similarly like any other country, the Mongolian Peoples Republic has full rights to become a member of United Nations Organization". Pandit Nehru in his address to the 15th UNGA, making a very convincing and strong case for Mongolia's admission to the United Nations, said, "If they received so many countries in the United Nations then why should Mongolia stay outside it? What had she done wrong? What kind of error did she commit with the Charter? The people of Mongolia are tranquil and her peace-loving toilers are firmly striving for progress, and it seems absolutely wrong, from the principle point of view, not to allow her to the great organization".

Soon after establishment of diplomatic relations, eminent Indian philosopher and politician, the then Vice President of India, Dr. S. Radhakrishnan paid a historic visit to Mongolia in 1957, which laid down the foundation of regular exchange of high level visits between our two countries. Since then three Vice President's of India Dr. Shankar Dayal Sharma (April 1992), KR Narayanan (Sept. 1996) and Krishan Kant (August 1999) have visited Mongolia. President of India R. Venkataraman paid a State Visit to Mongolia in July 1988. From Mongolian side, Prime Minister Tsendenbal (1973), Chairman of the Presidium Bathmunkh (March 1989), President P.Ochirbaat (February 1994), President N. Bagabandi (January 2001), and Prime Minister N. Enkhbayar (January 2004) visited India.

These regular high-level exchanges have played a significant role in promoting bilateral cooperation between our two countries in modern times. Our bilateral relations have been considerably strengthened in recent times. State Visits of President N. Bagabandi in January 2001 and Prime Minister N. Enkhbayar in January 2004 have provided a new impetus to our

ties. Since the visit of HE N. Enkhbayar our bilateral relations have been elevated to the level of partnership encompassing all possible areas of cooperation. Several new initiatives have been taken since then to enrich our bilateral ties.

Exchanges between the two parliaments have also been very intense. From Indian side Speakers of Lok Sabha Dr. G.S. Dhillon (July 1974), Dr. Balram Jhakar (Oct. 1985), Shiv Raj Patil (July 1995), P.A. Sangma (Oct. 1997) and G.M.C. Balayogi (July 2001) and the Deputy Chairperson of the Rajya Sabha Najma Heptullah led parliamentary delegations to Mongolia. From the Mongolian side Yu. Tsendenbal (1959& 1973), T. Batmunkh (1989), N. Bagabandi (1995), P. Gonchigdorj (1998) and S. Tumor Ochir (2003) led Mongolian parliamentary delegations to India. The two parliaments have close cooperation and have also signed a protocol to this effect.

Over the years, the two countries have signed 35 agreements on bilateral cooperation, which provide a comprehensive legal framework for cooperation in all areas of human activities. Some of the important agreements are: Treaty on Friendly Relations and Cooperation, Agreement on Trade and Economic Relations, Agreement on Avoidance of Double Taxation, Agreement on Defence Cooperation, Agreement on Cooperation in Agriculture, Extradition Treaty, Agreement on Mutual Waiver of Visa Requirements for Holders of Diplomatic and Official Passport, MOU on the Establishment of India-Mongolia Friendship Agropark for Research and Demonstration in Darkhan-Uul Aimag, MOU for Establishment of a Chair on Sanskrit and Buddhist Studies at the National University of Mongolia, Agreement to digitalize the Buddhist Manuscripts at the National Library of Mongolia, etc.

These high level exchanges have been duly supplemented by ministerial level visits and regular official exchanges. A complete list of the bilateral agreements signed is enclosed. In addition to the bilateral visits, the leaders of the two countries have also been meeting regularly on the sidelines of major international and regional conferences and gatherings. The two countries have a long tradition of closely coordinating their positions at international and regional fora. India greatly appreciates Mongolia's support to India's permanent membership for an expanded UN Security Council.

To symbolize the friendship between our two countries, a street in New Delhi, India was named as "Ulaanbaatar Street" and a street in Ulaanbaatar was named as "Mahatma Gandhi Street". The Statue of Mahatma Gandhi (Father of the Indian Nation) was unveiled on this street in July 2006. India and Mongolia have jointly issued commemorative postage stamps in September 2006.

India on its part has extended modest development assistance to Mongolia over the years. Brief details of India's development assistance are as follows:

(i) Scholarships: Over the years India has been extending scholarships to Mongolian students to pursue their higher education in Indian Institutions. Presently we award 40 scholarships [30 on permanent basis and 10 on the basis of availability] every year to Mongolian students. These scholarships are considerably popular among the student community in Mongolia. It gives me great pleasure to announce that several Indian educated Mongolians today occupy high positions in Mongolian Government as also in the private sector.

(ii) Training Programmes: In addition to the scholarship scheme, under India's Technical and Economic Cooperation Programme (ITEC), 50 training slots are being allocated every year

for Mongolian nationals for training in variety of fields, such as agriculture, small scale industry, information technology, banking, management, rural development, and so on. These training programmes have considerably helped Mongolia in development of its human resources.

(iii) Education: Under an Agreement signed between the two Governments, the Government of India had set up the Indo-Mongolia Joint Higher Secondary School in Ulaanbaatar in September 2003. Presently 5-Indian teachers are based in this School and they are teaching English, IT and Mathematics. India has also offered its assistance to Mongolia in updating and modernization of its School curricula and in introduction of e-education.

(iv) Vocational Training: In 1996, under India's Technical and Economic Cooperation Programme (ITEC), Rajiv Gandhi School of Art and Production (Rajiv Gandhi Vocational Training Center) with eight faculties was set up in Ulaanbaatar. These faculties are: Machine Shop; Auto Mechanics; Plumbing; Electrical Work; Radio & TV repairing; Computer Programming; Gemstone Cutting and Polishing and Printing. A total of about 450-students receive their vocational training in these faculties at the Centre every year. There is a proposal to add some new faculties to this Centre.

(v) Economic Assistance: A mini cement plant has been set up in Khovd province under a soft loan extended by India. During the visit of Prime Minister N. Enkhbayar to India, the Government of India had extended another soft loan of US\$10 million to enable the Mongolian authorities to import goods, services and projects from India. Presently talks are underway to enhance this soft loan to US\$20 million.

(vi) Information Technology: In IT sector, with a grant of US\$1 million, the Government of India had set up the Atal Bihari Vajpayee Centre for Excellence in Information and Communication Technology in October 2002. The Centre is equipped with sophisticated computer labs and the only Video Conferencing facility in Mongolia. As part of this Centre, the Government of India had also set up five Community Information Centres (CICs) in 5-Aimag capitals in Mongolia in 2002 at Gobi-Altai, Omnogobi, Arkhangai, Khentii and Selenge Provinces. During the visit of Prime Minister N. Enkhbyar to India in January 2004, it was agreed to further expand this Centre and in that connection five more Community Information Centres were set up at Khovsgol: (b) Bulgan; (c) Kharkhorin; (d) Dornod; & (e) Sukhbaatar Provinces.

As of now 16 Aimags capitals [State capitals] are connected to the Video Conferencing facility in Ulaanbaatar. The Government of Mongolia has already introduced limited distance education programme using this facility.

(vii) Digitalization: Mongolia is home to several precious manuscripts, which are a cultural and literary heritage of mankind. The two governments have decided to digitalize these precious manuscripts so that they could be preserved for eternity and could be made available to the mankind. An Agreement between the Indian Council for Cultural Relations (ICCR) and the National Library of Ulaanbaatar, Mongolia was signed on 9th June, 2006 to digitize the Buddhist Manuscripts. The Digitalization project for Mongolian Kanjur and Tanjur started in September, 2006 and is on way to completion.

(viii) Setting up of a Chair on Sanskrit and Buddhist Studies at the National University of Mongolia: A Chair on Sanskrit and Buddhist Studies at the National University of Mongolia, Ulaanbaatar was established as per the agreement between the Government of India and the Ministry of Education, Science & Culture of Mongolia in April, 2006 and since then the Chair

on study of Sanskrit and Buddhist philosophy has been functioning successfully at the National University of Mongolia. One Professor of Sanskrit taught for one semester in 2006 at National University of Mongolia and another will be coming to teach Sanskrit in 2nd semester in 2007.

(ix) Tele-Education & Tele-Medicine Project: During the official visit of former Foreign Affairs Minister of Mongolia Ts. Munh-Orgil to India in December 2005, the Government of India had announced Tele-education and Tele-medicine project for Mongolia. Under this project, Mongolian educational institutions would be connected to Indian educational institutions through a dedicated satellite. Similarly, one or two Mongolian hospitals will be connected to Indian medical institutions. These facilities will enable Mongolia to have direct access to quality education and medical services through use of modern technology.

(x) Agriculture: In 1998, under the agreement for cooperation in agriculture Indo-Mongolian Friendship Farm was set up near Darkhan. Since then some research work has also been under taken in the agricultural research lab in Darkhan for developing appropriate varieties of wheat and potato seeds suitable for Mongolian climatic conditions, which are characterized by low precipitation, short summer and harsh winter. It has now been decided to develop this Friendship Farm into a Model Agricultural Farm. Two Indian experts visited the farm in July 2004 in this regard. Indian experts would also be deputed to Mongolia to help Mongolian authorities in evolving appropriate policy framework in the field of agriculture and dairy development. The two countries are also cooperating in Yak research projects.

During the official visit of former Foreign Affairs Minister of Mongolia Ts. Munh-Orgil to India in December 2005, an MOU on the Establishment of India-Mongolia Friendship Agropark for Research and Demonstration was signed. Under this MOU, Government of India would provide agricultural equipments, tractors and trucks, sprinkler irrigation system. etc. for use at agropark

(xi) Solar Electrification: During the visit of Mongolian Prime Minister N. Enkhbayar to India in January 2004, Government of India had agreed for solar electrification of a village in Mongolia. Accordingly, Government of India had undertaken a pilot project for solar electrification of Dadal Soum in Khentii Aimag and has been successfully completed and was formally inaugurated in April, 2006.

(xii) Trade and Economic Ties: During the visit of PM Enkhbayar, the two PMs felt that our two countries have not been able to translate their close political and spiritual ties to mutually beneficial trade and economic exchanges. Therefore, it was decided to hold an exclusive India Trade Exhibition in Mongolia. This exhibition was successfully held from in September, 2004 in Ulaanbaatar. Conferences in the areas of IT, biotechnology and pharmaceuticals were also held coinciding with this exhibition to promote cooperation in these areas. This event generated considerable interest among the business community in the two countries. It appears that the bilateral trade, which had been hovering around \$1 million for years, has recorded considerable growth thereafter. India has also emerged as the one of the top destinations for education for Mongolian students. In addition to the Government of India Scholarships several students go to India to pursue their studies on self-financing basis.

(xiii) Defence: There has been good progress in the area of defence cooperation since October 2003. Mongolian Defence Minister paid a visit to India in November 2003 and in December 2005. Minister of State for Defence of India Shri M.M. Pallam Raju visited Mongolia

in May 2006. India has agreed to provide training facilities to Mongolian defence personnel in English language, peace keeping and military operations. Presently about 10-training slots are available for Mongolian defence personnel every year. The two countries also held two joint military exercises – the first one in Ulaanbaatar in October 2004, and the 2nd in India in December 2005. India participated at the ‘Khan Quest’ multilateral military exercises held in Ulaanbaatar in August, 2006. Government of India gifted parachutes to the Mongolian Armed Forces. Cooperation in other defence related areas is also under consideration.

A Joint Working Group on Defence Cooperation was set up and the first meeting of the India-Mongolia Joint Working Group on Defence Cooperation was held in Ulaanbaatar in March 2006.

Regular dialogue between the two National Security Councils has also been initiated to enable the two sides to exchange ideas on issues of bilateral and international concern.

(xiv) Spiritual And Cultural Ties: Given the ancient spiritual and cultural ties between our two countries, the Government of India had allocated a plot of land for construction of a Mongolian Monastery at Bodh Gaya. A foundation laying ceremony was held during the visit of Prime minister N.Enkhbayar to India. Construction of the Mongolian Monastery in this holiest place of Buddhism is to start very shortly. The Government of India created a Chair for Mongolian studies at the Jawahar Lal Nehru University in Delhi, which has functioned till 2005 and has now stopped.

(xv) Emergency Assistance: From time to time, as a good friend, India has provided food and medical supplies as emergency assistance to Mongolia during the time of crisis such as juud and drought.

In view of the above, it is clear that our two countries have maintained close ties over the last 50 years. These historic ties would acquire a new dynamism in the near future, which will bring the two ancient civilizations even closer.